



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/176

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, улсын болон орон нутгийн төсвөөр гүйцэтгэх худалдан авах ажиллагааны үйл явц, үр дүнгийн талаарх мэдээллийг олон нийтэд түгээн сурталчлах, худалдан авах ажиллагааны ил тод, үр ашигтай, хариуцлагатай байх зарчмыг хэрэгжүүлж, иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах зардалд зориулан 15,000,000 төгрөгийг хамтран ажиллах гэрээнд заагдсаны дагуу зарцуулсугай.

2. Тус зардалд зарцуулагдах 15,000,000 (арван таван сая) төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр арга хэмжээний 5.6 дахь заалт "Төрийн бүтээмжийг сайжруулах чиглэлийн хөтөлбөр"-өөс тооцож гаргахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Ганболд), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Батболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БОЛОРМАА

8400001.0215
Zah A/176-Kh